



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/288

Мандалговь

“Уяхан замбуу тивийн наран”
урлагийн их наадмыг нэвтрүүлэхэд
хөрөнгө гаргах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а” хэсэг, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлан гаргасан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалт нийтлэг журам”-ын 2.1.5, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Их газрын чулуу задгай театрын “Уяхан замбуу тивийн наран” урлагийн их наадмын бэлтгэл ажлын бичлэг, арга хэмжээг суртачлах, наадмын бичлэг хийх, нэвтрүүлэхэд хөрөнгө гаргасугай.

Хоёр. Урлагийн их наадмын талаарх бичлэг хийх, бүхий л арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-очир)-т даалгасугай.

Гурав. Тус арга хэмжээнд шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190822